

# “ЦАЙРТМИНЕРАЛ” ХХК

## СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН НУТАГТ ОРШИХ ТӨМӨРТИЙН ОВООНЫ ЦАЙРЫН УУЛЫН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



ТӨМӨРТИЙН ОВОО  
2025 ОН.

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

---

Төмөртийн овооны цайрын орд нь Монгол улсын дорнод бүс дэх Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт тус аймгийн төв Баруун-Урт хотоос хойш 13 км-т хойд өргөргийн 46° 48’ зүүн уртрагийн 113° 19’-н газар зүйн солбицолд оршдог.

Орд газар нь Дорнод Монголын их талын ухаа гүвээт хээр талын бүсэд оршдог, газрын гадарга нь харьцангуй тэгш, далайн төвшнөөс дээш 1000-1100 метрийн өндөрт байрладаг, харьцангуй өндрийн зөрүү нь 80-100 метр. Хамгийн өндөрлөг газар нь Төмөртийн Овоо уул, түүний үнэмлэхүй өндөр нь 1139.4м цайрын орд нь уг уулын урд бэлд 38 га талбайг эзлэн оршино.

Төмөртийн-Овооны Цайрын Уулын Баяжуулах Үйлдвэр нь 2005 оны 8-р сарын 28-нд ашиглалтад орсноос хойш өнөөдрийг хүртэл тасралтгүй, тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Тус үйлдвэр жилд дунджаар 350-400 мян.тн цайрын хүдэр боловсруулан дунджаар 50%-н агуулгатай, 90-100 орчим мян.тн цайрын баяжмал үйлдвэрлэн, экспортод гаргадаг.

### 1.1. Байгаль орчин хамгаалах ажлын хууль зүйн үндэс

Монгол улсын “Байгаль орчны хамгаалах тухай хууль”, “Ашигт малтмалын тухай хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”, Засгийн газрын холбогдох тогтоолууд, Байгаль орчны яамнаас гаргасан журам, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан заавруудыг мөрдөн 2025 онд төлөвлөсөн дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн билээ.

## ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

### 2.1. Болзошгүй болон сөрөг нөлөөллийн тодорхойлолт

- Агаар мандал  
Өрөмдлөг тэсэлгээ, уулын цул тээвэрлэх явцад агаар мандалд зохиомол тоос ихээр үүсч орчныг бохирдуулах мөн дотоод шаталтад хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчны хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно. Мөн үүний зэрэгцээ хаягдлын санд төвлөрүүлэх хаягдлын нарийн ширхэгтэй хэсэг салхины нөлөөгөөр агаар мандалд дэгдэх байдал бий болох.
- Ус  
Сүхбаатар аймгийн Асгат сумын нутагт байрлах “Шинэ ус”-ны усны ордоос үйлдвэрийн бүс хүртэл усны трассын эргэн тойрон, усны эх үүсвэр газарт ундны усны эрүүл ахуйн дэглэм зөрчигдөх.
- Хөрс, ургамал, газар  
Хөрс хуулалт, тээвэрлэлт, уурхайн зам, хөрс чулуулаг, хүдрийн овоолго, хаягдлын сан, барилгын суурь бэлтгэх ажлаас хөрсний бүтэц эвдэрч, үржил шим буурч ургамал устгах, талхлагдах зэрэг нөлөөлөлд орно. Байгалын унаган хэв шинж алдагдана. Газрын хөрс ахуйн хаягдал, шатахуун, тослох материалаар бохирдож болзошгүй. Химийн хорт бодисыг байгальд шууд хаях.
- Зэрлэг амьтан, мал  
Зэрлэг амьтдын амьдрах орчин мөхөс болох мөн гэнэтийн болон өндөр давтамжийн дуу чимээ зэргээс үргэн дайжих, мал амьтан ухсан нүх сувагт унаж бэртэх, үхэж хоргодох зэрэг сөрөг үр дагавар гарч болзошгүй.
- Ажиллагсад, оршин суугчдын эрүүл мэнд  
Орчны тоос, тоног төхөөрөмжийн ажиллагааны үед гарах дуу чимээ, тоос нь ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, хөдөлмөрийн чадварыг бууруулж болзошгүй. Үүний зэрэгцээ үер, гал түймэр, аянга, цахилгаан зэрэг байгалийн гэнэтийн аюулд өртөж болзошгүй.
- Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах  
Хөрс хуулах, барилгын суурь тавих, барилга угсралтын ажлыг технологийн горимын дагуу гүйцэтгэж орчныг талхлахаас аль болох зайлсхийх, энэ чиглэлээр олон нийтийн зүгээс тавих хяналтыг сайжруулах нь зүйтэй.

### 2.2. Нөлөөлөх хүрээ

- Уурхайн ажиллагсад, ойр орчмын айл өрх, мал сүрэг, агаар мандал, хөрс, ус, ургамал, ан амьтан.

### 2.3. Түүх соёлын дурсгалыг хамгаалах

- 2025 оны уулын ажлын явцад ямар нэгэн ховор олдвор илрээгүй бөгөөд үүнтэй холбоотой асуудал гараагүй болно.

## 2.4 2025 онд байгаль орчинд нөлөөлөх байдлыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.

**Төмөртийн-Овооны уулын баяжуулах үйлдвэрийн 2025 онд хийгдсэн ажлуудтай уялдуулан байгаль орчинд сөргөөр нөлөөлөх байдлыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн ажлын чиглэл:**

- А. Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авах арга хэмжээ
- Б. Нөхөн сэргээлт
- В. Химийн бодисын эрсдэлийн менежмент, Хог хаягдлын менежмент
- Г. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын ерөнхий асуудлаар

### **А. Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авах арга хэмжээ**

1. Ил болон далд уурхайн тэсэлгээг хийхдээ тухайн өдрийн цаг агаарын байдлыг харгалзан үзэж аль болох салхи багатай, салхины чиглэл Баруун-Уртын чиглэлээс өөр байх нөхцөлийг сонгож, тэсэлгээний ажлыг орчин үеийн технологийн дагуу хийж материалын сонголтыг тохируулан хэрэглэж байсан учраас зохиомол тоос үүсэх байдлыг хязгаарлаж чадсан. Ил болон далд уурхайн уулын ажлын түвшин доошлох тусам байгалийн салхины үйлчлэлээр тоос босох үзэгдэл буурч байна. Далд уурхайн тэсэлгээний ажил хийх явцад сийрэгжилттэй газарт тэсэлгээний чичэрхийлэл өгвөл тухайн газар доошоо нуралт өгөх боломжтой тухайн нуралт өгсөн газар ургамал болон гол горихны ундрага ихтэй газар байж болно. Тэсэлгээ хийгдсэний дараа вентилятор сорож авсан агаараа босоо амруу гаргах бөгөөд хортой агаар нь байгальд сөрөг нөлөө үзүүлж болно.
2. Хүчтэй аадар бороо орох, хүчтэй салхилах, шороон шуурга шуурах, хээрийн гал түймэр зэрэг байгаль цаг уурын аюултай үзэгдлийн үед уурхайн олборлолт, тээвэрлэлт, ачилт буулгалтын үйл ажиллагааг түр зогсоох, техник хэрэгслүүдийг унтрааж, ажиллагааг зогсоох арга хэмжээг цаг тухайд нь авч нөлөөллийн бүсийн айлуудад хуурайшилтын үед тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх мэдээллийг тогтмол өгч байсан. (Зураг 1)



Зураг 1. Нөлөөллийн бүсийн айлуудад мэдээлэл өгч байгаа нь

3. Зам харгуйг засварлан сайжруулж олон салаа замыг багасган төсөлд тусгагдсан байдлаар тодорхой чиглэлээр уурхайн замуудыг байгуулсан бөгөөд арчилгаа тордолтыг цаг алдалгүй гүйцэтгэж, тээвэрлэлт хийх авто машинуудын хоорондын зайг 5 минут байхаар зохицуулан, технологийн замыг тогтмол усалж байна. (Зураг 2)



Зураг 2. Замын усалгаа

4. Хүнд механизм, тээврийн хэрэгслийн тохиргоо, үйлчилгээг байнга хийж шаардлагатай хугацаанд нь үзлэг оношилгоог хийн дотоод шаталтад хөдөлгүүрээс гарах утааг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгаж байна.
5. Уурхайн дотоод тээврийн маршрут болон лицензийн талбайн орчмын замыг тэмдэгжүүлж, шинээр олон салаа зам үүсгэж хөрс эвдэхгүй байх арга хэмжээг авч ажиллаж байна. ( Зураг 3 )



Зураг 3. Уурхайн дотоод тээврийн замын тэмдэг тэмдэглэгээ

6. Шатах тослох материалыг зориулалтын дагуу стандартын шаардлага хангасан агуулахад хадгалдаг ба шатахууны агуулахын битүүмжлэлийг сайтар хангаж хөрс бохирдуулахаас сэргийлж, тээврийн хэрэгслийг түлш, шатахуунаар цэнэглэх үед шатах тослох материал асгарч, алдагдахаас сэргийлэн зориулалтын шингэн нэвтрэхгүй, шатдаггүй материал дэвсэж хөрсөн бүрхэвч бохирдохоос сэргийлж байна.
7. Хөрсний болон хоосон чулуулгийн овоолгыг салхины зонхилох чиглэлд, газар зүйн байрлалыг тооцон нуралт, гулсалт бага байхаар байршуулан технологийн дагуу байгуулж байна. Хөрсний чулуулгийн физик шинж чанараас хамааруулан 20 м хүртэл өндөртэй догол болгон хурааж байна. (Зураг 4)



*Зураг 4. Хоосон чулуулгийн овоолго*

8. Баяжуулах үйлдвэрийн бутлуур болон технологийн дамжлагуудаас ялгарах тоосыг багасгах зорилгоор хятад улсад үйлдвэрлэсэн усан манан үүсгэгч тоос дарах төхөөрөмжийг суурилуулан байгаль орчин болон, үйлдвэрийн эрүүл ахуйн нөхцөл байдлыг сайжруулж, тоосжилтыг стандартын хэмжээнд барьж байна. (Зураг 5 )



*Зураг 5. Усан манан үүсгэгч төхөөрөмж*


9. Хаягдлын далангийн хиймэл нуурын ус болон ахуйн бохирын цэвэршүүлсэн усыг улирал бүр ЗГХА-Усны газрын лабораториор болон бусад итгэмжлэгдсэн лабораториудаар хаягдал усны шинжилгээ хийлгэн хяналт тавин ажиллаж байна.

10. Унд, ахуйн зориулалттай усны эх үүсвэр Монгол улсын холбогдох стандартын шаардлагыг хангаж эрүүл ахуй, халдвар судлалын хувьд найдвартай хамгаалагдсан байх нөхцөлийг бүрдүүлэн усны эх үүсвэрээс тодорхой зайд хүн мал орохоос сэргийлэн татсан торон хашаагаа тогтмол сэргээн засварлаж байна. Эргэн тойронд нь анхааруулах самбар суурилуулж хамгаалалтад аван гадна орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэх ажлыг тогтмол хийж байна. Мөн гэрээт харуулаар байнга хянуулж байна.
11. Ундны усыг эрүүл ахуйн стандарт шаардлагад нийцүүлэх үүднээс ус цэвэршүүлэх төхөөрөмжийг хагас жил тутамд 1 удаа сольж, түүхий усны сан болон шугам хоолойг угаадаг. Шаардлагатай тохиолдолд тухай бүр нь арга хэмжээ авдаг. (Зураг 6)



*Зураг 6. Ундны усны цэвэршүүлэх төхөөрөмж*

12. Ахуйн бохир усыг цэвэршүүлэх талаар онцгой анхаарч нэмэлтээр Хятад улсад үйлдвэрлэсэн ус сайжруулж, зөөлрүүлэх тоног төхөөрөмжийг суурилуулсан ба зургаан сар тутамд фильтрийг сольж ажиллаж байна.
13. Хаягдлын далангийн доод хэсэгт хяналтын 2 цооног өрөмдүүлж улирал бүр дээж авч мэргэжлийн байгууллагаар шинжлүүлэн байнгын хяналт тавьж ажиллаж байна.
14. Усны орд эх үүсвэрийн худгуудын цооногын түвшний хэмжилт, усны тоолуурын заалтыг сар бүр Татварын улсын байцаагч байлцуулан хэмжиж баталгаажуулан акт үйлддэг. Усны хэрэглээ ашиглалтын тайланг жил бүр Засгийн Газрын Хэрэгжүүлэгч агентлаг Усны газар болон, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаанд хүргүүлж, холбогдох дүгнэлт, гэрээ зөвшөөрлийг авч ажиллаж байна. Мөн усны эх үүсвэрийн худгуудын цооногын хамгаалалтын хашааны засварын ажил хийгдсэн. (Зураг 7)



Зураг 7. Усны орд эх үүсвэрийн хүдгүүдын цооногын түвшний хэмжилт, усны тоолуурын заалт авч буй байдал

15. Ил болон далд уурхайн гүний уснаас дээж авч мэргэжлийн лабораторид шинжлүүлдэг ба хүнд металлын агууламж болон бусад элементүүд стандартаас давсан үзүүлэлт илрээгүй болно.

16. Хаягдлын далангийн тоос хийсэж хөрс бохирдуулж болзошгүй тул дүүргэлт хийсэн хэсэгт хоосон чулуулгаар хучилт хийж мөн дулааны улиралд бороожуулах систем ашиглан тоосжилтыг бууруулах арга хэмжээ авсан. ( Зураг 8 )



*Зураг 8. Далан дээр бороожуулагчаар усан манан үүсгэж байгаа байдал*

17. Гал түймрээс хамгаалах зурвасыг жил бүр шинэчлэн татах, сайжруулах ажлыг тогтмол хийж байна.
18. Уурхайн орчимд зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнтэй таарвал үргээлгүй зам тавьж өгөн өнгөрөөж, бэртэж гэмтсэн, аюулд орсон зэрлэг ан амьтантай таарвал орон нутгийн байгаль хамгаалагчид мэдэгдэж шуурхай арга хэмжээ шуурхай аван ажилладаг.
19. Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам дагуу 2025 оны 07 дугаар сарын 01-03 ны өдөр 6 хүний бүрэлдэхүүнтэй замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах ажлыг маршрутын дагуу 80 км хүртэлх замд хийж гүйцэтгэлээ. Үүнд: цацруулагчтай 2 талт самбар 6 ширхэгийг шинээр байрлуулан 8 ширхэг хуучирч, бүдгэрсэн самбарыг сэлбэж, тодруулсан. ( Зураг 9 )



*Зураг 9: Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах ажил*

### **Б. Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд хийгдсэн ажил.**

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, тогтвортой хөгжлийн хүрээнд 2025 оны хаврын мод тарилтад уурхайн бүсэд нийт 10062 ш (8000 хайлаас, 300 агч, 1600 улиас, 55 монос, 50 голт бор, 37 нарс, 5 гүйлс, 15 бүйлс) мод тарьж суулгасан ба ургалтын хувь 97 хувьтай байна. Мөн Асгат суманд нийт 1000 ширхэг улиас модыг хүлээлгэн өгсөн.

Орчны цэцэрлэгжүүлэлтэд төрөл бүрийн нэг болон олон наст ургамлыг тариалан тохижилтод анхааран ажиллаж байна. (Зураг 10,11)



*Зураг 10. Орчны цэцэрлэгжүүлэлт*





*Зураг 11. Уурхайн орчинд тарьсан мод “Тэрбум мод” үндэсний аян*

2. Хөрсний үржил шимтэй хэсгийг Монгол улсын стандарт, шаардлагын дагуу хуулж тусгайлан овоолго бий болгон хэлбэршүүлж овоолгын бүсэд хурааж хашаажуулсан. (Зураг 12)




*Зураг 12. Үржил шимт хөрс хуулж хашаажуулсан байдал*

3. Хаягдлын далангийн дүүргэлт хийсэн 0,5 га талбайг шимт хөрсөөр хучиж соргүй согоовор, царгас зэрэг олон настын үр цацаж ургамалжуулах маягаар техник болон биологийн нөхөн сэргээлт хийсэн. ( Зураг 13,14 )



*Зураг 13. Техникийн нөхөн сэргээлт хийсэн 0,5 га талбай*





Зураг 14. Биологийн нөхөн сэргээлт хийсэн 0,5 га талбай

4. Далд уурхайгаас үүдэлтэй эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг тухай бүрт тэгшилт хэлбэржүүлж талбайд шимт хөрсөөр хучилт хийх, ургамалжуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Далд уурхай нь ил газрын гадарга дээр эвдрэл үүсгэх нь бага тул бид далд уурхайд ордын олборлосон орон зайд дүүргэлт хийх системийг ашиглаж байгаа бөгөөд дүүргэлтийн системийн гол зорилго нь олборлогдсон орон зайг дүүргэж уулын даралтыг тогтоон барихад оршино.
5. Газрын тухай хуулийн шаардлагын дагуу Асгат болон Сүхбаатар сумтай газар ашиглалтын гэрээ байгуулж ашиглалтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрын төлбөр хураамжийг цаг тухайд нь холбогдох байгууллагад нь төлж байна.
6. Баяжуулах үйлдвэрийн дэргэд үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлыг зориулалтын талбайд уурхайн зонхилох салхины чиглэлийн дор буюу зүүн урд хэсэгт тусгай зөвшөөрөл бүхий талбайд байгуулсан.
7. “ Ланд Овнер” ХХК-тай хамтран байгаль орчны хяналт шинжилгээг хөрс, ус, агаар, амьтан, ургамал орчинд химийн шинж чанар, хүнд металл, нянгийн бохирдол, тоосжилт, цацраг идэвхжилт, амьтан ургамлын судалгаа гэсэн бүлэг үзүүлэлтээр хавар намрын улиралд буюу жилд 2 удаа гэсэн давтамжаар хийж байна. ( Зураг 15,16,17 )



Зураг 15. Агаар, ургамлын судалгаа авч буй байдал.

8. Хөрсний мониторингийн 14 цэг дээр мониторингийн ажиглалт тэмдэглэл хийж сорьц дээж авч шинжлүүлсэн.



Зураг 16. Хөрсний мониторингийн дээж авч буй байдал



Зураг 17. Усны дээж авч, шинжилгээ хийж буй байдал

**В. Химийн бодисын эрсдэлийн менежмент, Хог хаягдлын эрсдэлийн менежмент**

1. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд байнгын хяналт тавин ажиллаж байна.
2. “Химийн хорт болон аюултай бодисын үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө” боловсруулж аймгийн онцгой байдлын газраар батлуулан мөрдөж байна.
3. Компанийн химийн бодисын агуулахад “Химийн бодисын нарийвчилсан үнэлгээ” хийлгэж үнэлгээнд тусгагдсан ажлуудыг шат дараалалтайгаар хийж гүйцэтгэж байна.
4. Үйлдвэрийн химийн бодисын агуулахад химийн бодис асгарсан тохиолдолд саармагжуулан зайлуулах шуудуу татаж сэргийлсэн. Мөн хор аюулын лавлах болон аюултай бодисын тэмдэглэгээ, гал унтраах хэрэгсэл зэргийг нэмж байрлуулсан.
5. “Цэцүүх трейд” ХХК-ийн оруулж ирдэг химийн бодисын асгаралтын иж бүрдлээс том жижиг гэсэн хоёр төрлөөс авч химийн бодисын агуулах болон химийн бодис хэрэглэгддэг газруудад байрлуулж зааврыг холбогдох хүмүүст танилцуулсан.  
(Зураг 18)



Зураг 18. Химийн бодисын асгаралтын иж бүрдэл

6. Хүдрийн дээж авагч машиныг шинээр хийж тээрмийн цехэд суурилуулсан. Мөн лабораторид шинээр дээж шүүгч болон нунтаглагч машин сольсон. ( Зураг 19)



*Зураг 19. Химийн бодисын шүүгээ*

7. Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн А/21 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу аюултай хог хаягдлын тоо бүртгэлийг хөтөлж тайланг улирал бүр аймгийн байгаль орчны газарт хүргэдэг.
8. Аюултай хог хаягдлыг хадгалах түр агуулахад аюултай хог хаягдлыг саармагжуулан хадгалдаг бөгөөд “Хай Би Ойл” ХХК-тай гэрээ байгуулан 2025 оны 7 дугаар сард 800 литр хаягдал тос, масло тушааж устгуулсан. Мөн “Элемент” ХХК-тай гэрээ байгуулан 2025 оны 10 дугаар сард химийн бодисын шил нийт 4050 кг, хар лав нийт 9200 л тушааж устгуулсан.
9. Хатуу хог хаягдлыг хадгалах гэрээг Сүхбаатар сумын ЗДТГ-тай жил тутам хийн улирал бүр төлбөрийг шилжүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Мөн хог хаягдлыг ангилан ялгаж сар бүр хуванцар хог хаягдлыг ангилан хурааж аймгийн хот тохижуулахад тушаан өгдөг.

**Г. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын ерөнхий асуудлаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн болно. Үүнд:**

1. Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, энэ чиглэлээр үүрэг хариуцлагыг дотоод журамд тусган ажиллаж, үйлдвэрийн дэргэдэх лабораторид байгаль орчны зарим шинжилгээг хийж зохих үр дүнд хүрч байна.
2. Төмөртийн-Овооны УБҮ-ийн ТЭЗҮ шинэчлэгдсэнтэй холбоотойгоор МУЗГ-н 2023 оны 02 сарын 08-ны өдрийн 58-р тогтоолын дагуу Төмөртийн-Овооны УБҮ-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэсэн.

3. Байгаль орчны асуудлыг хариуцан зохион байгуулах үүргийг компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин хариуцсан хэлтсийн байгаль орчин хариуцсан мэргэжилтэн гардан хийж байна.
4. Ажилчдад хор саармагжуулах бүтээгдэхүүн БИОТ 2 уургийн баяжмалыг 200гр савалгаатай 1 ширхэгийг нэмэлтээр энэ оны 5 дугаар сараас ЛАГШИН тунгалаг хармаг жимсний 50% ийн шүүсийг 500мл савалгаатайгаар олгож эхлээд байна.
5. Байгаль орчны аудитыг “Энвйронментал комплайц” ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн.
6. Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад улиралд тогтсон хөтөлбөрийн дагуу 2025 оны 3-р улирлын нийт ажилтны сургалтыг Байгаль орчны чиглэлээр мэргэжлийн сургагч багштай хамтран зохион байгуулсан . ( Зураг 20)



Зураг 20. Сургалт явуулж байгаа байдал.


7. Бүх ажиллагсдыг жил бүр эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулдаг.
8. Үйлдвэрийн бүсэд хог хаяхгүй байх талаар анхаарал тавьж зориулалтын хогийн савыг байршуулан цэвэр цэмцгэр, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж хэвшсэн.
9. Байгаль орчны нөхөн сэргээлтийн төлөвлөгдсөн ажлыг хийхэд аймгаас ажилгүй 10 гаруй иргэнийг түр хугацааны ажлын байр гарган орон нутгийн иргэдийг авч ажиллуулдаг.
10. Уурхайн бүсэд аваар осол гарахаас сэргийлж бүх объектийн галын гарцын схемийг шинэчилж, замын тэмдэг, тэмдэглэгээг сэргээн засч шинээр байрлуулсан. Мөн үйлдвэр болон далд уурхайд аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээг шинээр нэмж авч байрлуулсан.
11. Уурхайн бүсэд ажлын байрны бичил эко орчин бий болгож ажиллах таатай орчинг бүрдүүлж өгсөн. ( Зураг 21 )



*Зураг 21. Ажлын байрны орчин*


#### **Д. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд**

1. Цайртминерал ХХК-ийн хамт олон дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд “ Уул уурхайн олборлолтын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх акт”-н дээр тусгасаны дагуу Сүхбаатар сумын нутаг дах биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр монгол орны нэн ховор амьтныг хамгаалах , хулгайн анд өртөх байдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор монгол тарваганы тархац нутагт ажиглалт хяналтын камер суурилуулах ажлын хүрээнд тог цахилгаан шаардлагагүй, хөдөлгөөн мэдэрч бүрэн утаснаасаа хянах боломжтой үзүүлэлт бүхий 2 ширхэг камерийг шалгаж тохируулан хүлээлгэн өгсөн. (Зураг 22)



*Зураг 22. Камер хүлээлгэн өгч буй явц*



2. Цайртминерал ХХК-ийн хамт олон дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баянцагааны талын байгалийн нөөц газарт нийт 40ш Шувууны суултуур (үүр) суулгасан. (Зураг 23)





*Зураг 23. Шувууны үүр суулгаж буй явц.*

3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Чиглэл хүргүүлэх тухай” 2020 оны 12 дугаар сарын 22-ны 01/8786 тоот албан бичигт заасны дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд нь Түвшинширээ сумын Бумбат нэртэй эвдэрч эзэнгүй орхигдсон газарт 1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. (Зураг 24)





Зураг 24. Техникийн нөхөн сэргээлтийг хийж буй явц

**Төсвийн зарцуулалт  
2025 оны байдлаар**

№	Гүйцэтгэх ажлын нэр	Зардал мян.төг
<b>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>		
1.	Гал түймрээс хамгаалах зурвас татах.	Туслан гүйцэтгэгч
2.	Ахуйн бохирын сангийн усыг стандарт хэмжээнд байлгах.	1500.0
3.	Байгаль орчны мониторинг	17690.0
4.	Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам, засварын ажил	2000.0
5.	Уурхайн дотоод тээврийн маршрут болон лицензийн талбайн орчмын замын тэмдэг тэмдэглэгээ	1500.0
6.	Хаягдлын далан дээр хоосон чулуулгаар хучилт хийх	36500.0
		<b>59190.0</b>
<b>Нөхөн сэргээлтийн арга хэмжээ</b>		
1.	Техникийн нөхөн сэргээлтийн зардал	19607.6
2.	Биологийн нөхөн сэргээлтийн зардал	49343.0
3.	Мод бут тарих	44870.0
4.	Шимт хөрс хуулах, зөөх	8800.0
		<b>122620.6</b>
<b>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ</b>		
1.	Хяналтын камер	4650.0
2.	Баянцагааны талын байгалийн нөөц газарт шувууны үүр суулгах ажил	2692.0
3.	Түвшинширээ сумын Бумбат 1 га талбайд техникийн нөхөн сэргээлт	16460.0
		<b>23802.0</b>
<b>Химийн бодисын эрсдэлийн менежмент</b>		
1.	Агаарын шинжилгээ	Мониторинг
2.	Химийн бодисын самбар, тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх, химийн бодис материалын хадгалалтыг стандартад байлгах	400.0
3.	Химийн бодисын асгаралтын иж бүрдэл	6380.0
4.	Химийн бодис дээж шүүгч болон нунтатлагч машин	6000.0
		<b>12780.0</b>
<b>Хог хаягдлын менежмент</b>		
1.	Хатуу хог хаягдлын төлбөр	2400.0
2.	Хог хаягдлын цэгийн ариутгал	850.0

3.	Аюултай хог хаягдал тушаасан төлбөр	
	“Элемент” ХХК - 4050 кг химийн бодисын шил, 9200 л хар лав тушааш устгасан	64278.5
	“Хай Би Ойл” ХК - 800 л техникийн хаягдал тос масло тушааж устгасан	120.0
		<b>67648.5</b>
<b>Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ</b>		
1.	Мэргэжлийн байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгаа хийх.	2000.0
2.	Галын гарцын схем, анхааруулах самбар, тэмдэг тэмдэглэгээ гаргаж, шинэчлэх	500.0
3.	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах. Далд уурхай болон баяжуулах үйлдвэрийн тэмдэг тэмдэглэгээ.	3022.5
4.	Байгаль орчны аудит	17100.0
		<b>22622.5</b>
<b>Нийт дүн</b>		<b>308663.6</b>